

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.

#### Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

**Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:**

**Дагаж мөрдөх огноо:**

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:**

2023. 12. 27

#### Байгууллагын нэр:

Цагдаагийн өрөнхий газар

#### Нэгжийн нэр:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн  
байгууллага

#### Албан тушаалтны нэр:

Хэв журмын ажил хариуцсан ахлах  
байцаагч

#### Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-6

#### Ажлын цаг:

8 цаг

#### Ажлын байрны албан ёсны нэршил:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн  
байгууллагын байр

#### Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

#### Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын  
гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон  
бусад аюул тохиолдсон, нийтийн эмх  
замбараагүй байдал үүссэн, террорист  
халдлага, онц болон дайны байдал  
зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн  
зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн  
бэлэн байдалд ажиллах.

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ.

#### Албан тушаалын зорилго:

Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомж нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг  
сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг  
хангах чиг үүргийг хэрэгжүүлэх, хяналт тавих, алба хаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар  
хангах, удирдлагыг орлох, өгсөн үүрэг, чиглэлийг гүйцэтгэх, зохион байгуулах.

#### Албан тушаалын зорилт:

- Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, үр дүнг тооцох, тайлагнах.
- Хариуцсан чиг үүргийн хүрээнд алба хаагчдын мэдлэг, үр чадварын түвшнийг дээшлүүлэх,  
мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавих.
- Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг  
үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1.Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, үр дүнг тооцох, тайлагнах;</p> <p>1.2.Удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журам, үүрэг, ажлын чиглэл, албан даалгавар, заавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр санал, танилцуулга бэлтгэх, боловсруулах, танилцуулах;</p> <p>1.3.Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг сахиулах, холбогдох дүрэм, журам, заавар, зөвлөмжийг боловсронгуй болгох санал бэлтгэн танилцуулах, тасгийн алба хаагчдад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;</p> <p>1.4.Цагдаагийн байгууллагад хуулиар харьялануулсан зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч, зөрчлийн хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, шалган шийдвэрлэх;</p> <p>1.5.Цагдаагийн байгууллагаас тавих захиргааны хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, танилцуулах, тайлагнах;</p> <p>1.6.Алба хаагчдын ажлын арга зүйг тодорхойлох, ажлын байрны заавар, зөвлөмжийг боловсруулах, санал, танилцуулга бэлтгэх, танилцуулах;</p> <p>1.7.Нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагаас зохион явуулж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, үр дүнг тооцон танилцуулах, санал, танилцуулга, төсөл хөтөлбөр бэлтгэх, тайлагнах;</p> <p>1.8.Хорио цээр, хязгаарлалтын дэглэм сахиулах, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэрч хохирогчийг хамгаалах, жагсаал, цуглааныг албадан тараах, нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтад ажиллах, зохицуулалт хийх, удирдлагаас өгсөн үүргийг хэрэгжүүлэх, үр дүнг танилцуулах;</p> <p>1.9.Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, гадаад орнуудын</p>	Хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хангагдана.	Г Г Г Г Г Г Г Г Г Г

	<p>туршлагыг судлах, санал, танилцуулга хүргүүлэх, алба хаагчдад гарын авлага, материал, бэлтгэх;</p> <p>1.10. “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;</p>		Г
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1.Хариуцсан чиг үүргийн хүрээнд бүртгэл судалгаа гаргах, хөтлөх, хяналт тавих, танилцуулах;</p> <p>2.2.Гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ, бүртгэл, судалгаанд үндэслэн нутаг дэвсгэрийн хэв журмын нөхцөл байдалд дун шинжилгээг хийж, үйл ажиллагаандаа ашиглах;</p> <p>2.3.Хариуцсан чиг үүргийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын дун мэдээ, гүйцэтгэлийг сар, улирал, хагас, бүтэн жилээр тооцох, дун шинжилгээ хийх, удирдлагад танилцуулах;</p> <p>2.4.“Цагдаагийн байгууллагын туслах тоо бүртгэлийн заавар”-ын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>2.5.Албаны галт зэвсэг, техник, хэрэгслийг бүртгэх, олгох, хадгалах, хяналт тавих журмыг хэрэгжүүлэх, хүч хэрэгслийн тооцоо, судалгаа, бүртгэл хөтлөх, танилцуулах.</p> <p>2.6.Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан заавар, зөвлөмж, арга зүйн туслалцаа үзүүлэх, зааварчлах, удирдлагын баримт бичгийг боловсруулах, бүрдүүлэх.</p> <p>2.7.Алба хаагчдын ажлын байранд нь мэргэшүүлэх чиглэлээр сургалт, дадлага зохион байгуулах, үр дүнг танилцуулах.</p> <p>2.8.Хэсгийн байцаагч, сум, баг, хорооны цагдаа нарын өдөр тутмын үйл ажиллагааг шалган зааварчлах, ахлах байцаагч нартай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн, соён гэгээрүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлж, зохион байгуулах, алба хаагчдын сахилга ёс зүйн байдалд хяналт тавьж илэрсэн зөрчил дутагдлыг засуулах арга хэмжээ авах.</p>	Алба хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилнэ.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	<p><b>Ажлын байрны зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа:</b></p> <p>1.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.</p> <p>2.Шууд удирдах албан тушаалтнаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврын биелэлтийг хангах</p> <p>3. Албан хэрэг хөтлөлт, архивын журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах</p> <p>4.Төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд</p>	Ажлын байрны зорилго, зорилт хангаждаж, цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээлгэсэн нийтлэг чиг үүргийн	Г

	<p>болон харилцагч, үйлчлүүлэгчид иргэдтэй зөв боловсон харьцах ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх</p> <p><b>Шударга ёсны шалгуурыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар:</b></p> <p>1.Авлыга, хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг чанд сахих;</p> <p>2.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.</p>	биелэлт хангагдана.	Г
			Г
			Г

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

<b>Боловсрол</b>	-Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй		
<b>Мэргэжил</b>	-Эрх зүй /0421/, Аюулгүй байдал судлал /103901/, Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/;		
<b>Мэргэшил</b>	-Албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.		
<b>Туршлага</b>	Цагдаагийн байгууллагад 5-аас доошгүй жил, офицерын албан тушаалд 2-оос доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байх.		
<b>Үр чадвар</b>	Удирдан зохион байгуулах	-Хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах -Удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдах чадвартай -Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх	
	Дүн шинжилгээ хийх	-Албан ажлын хэрэгцээнд шаардлагдах мэдээлэл цуглуулж, дүгнэх -Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг дүгнэх	
	Асуудал шийдвэрлэх	-Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх	
	Манлайлах	-Ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дуурайлал үзүүлэх -Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах -Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх.	
	Бусад		

### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

<b>Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:</b> Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн дарга	
<b>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</b>  Батлагдсан орон тоо.	<b>Бусад харилцах субъект:</b>  <b>Шууд харилцах:</b> Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан.  <b>Шууд бус харилцах:</b> Төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.

**V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

<b>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</b>  Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  Т.ГАНЗОРИГ  2023 оны 11 дугаар сарын 22-ны өдөр	<b>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</b>  Байгууллагын нэр:..... Шийдвэрийн огноо:..... Дугаар:.....
<b>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</b>  Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27-өдөр. Дугаар: 1/101  ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА	
 Т.СУХБОЛД  2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр	

**Танилцсан:**

Танилцсан албан тушаалтан: ..... .....
20... оны .... дугаар сарын ....-ны өдөр